

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

№ 18/39

Улаанбаатар хот

Зээлийн эх үүсвэр татан төвлөрүүлэх эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсэг, 80 дугаар зүйл, 87 дугаар зүйлийн 87.1 дэх хэсэг, 88 дугаар зүйлийн 88.1 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.4, 9.6.19 дэх хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан БОГД банкнаас дараах нөхцөлийн дагуу гэрээ байгуулж зээл авах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.

Зээлийн хэмжээ	2 (хоёр) тэрбум төгрөг хүртэл
Зээлийн хэлбэр	Зээл
Зээлийн хугацаа	2 хүртэл жил
Зээлийн хүү, шимтгэл	Жилийн 18%
Эргэн төлөх нөхцөл	Зээлийн хүүгийн төлбөр сар бүр, үндсэн төлбөр банктай тохирсон нөхцлийн дагуу
Барьцаа хөрөнгө /Сонголтоор/	ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн багц буюу шаардах эрх;

2. Зээл авах асуудлаар БОГД банкинд хүсэлт гаргах, зээлийн судалгаанд шаардлагатай мэдээлэл, материалыг бүрдүүлж, хүргүүлэх, зээлийн нөхцөлийг энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд хэлэлцэн тохирох, Зээлийн болон Барьцааны гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
3. БОГД банктай байгуулсан Зээлийн гэрээ, санхүүжилтын нөхцөлийг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.
4. Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг СЗХ-оос олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж буй ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагаанд зарцуулахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.



ГУЗ-ИЙН ДАРГА:

..... /О.БОЛДБААТАР/

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр

№ 18/40

Улаанбаатар хот

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь хэсэг, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн дүрмийн 9.6.5, 9.6.6 дах хэсгийг тус тус үндэслэн Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь:**

1. ЛэндМН ББСБ ХК-ийн зээлийн үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зориулан БОГД банкнаас 2 тэрбум төгрөгийн зээл авч буйтай холбоотойгоор уг үйл ажиллагаанд зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээдтэй “Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г дараах нөхцөлөөр байгуулсугай.

Зээлийн хэмжээ	2 (хоёр) тэрбум төгрөг
Зээлийн хэлбэр	Зээл
Зөвлөх үйлчилгээний хөлс	0,5%

2. Энэхүү тогтоолд заасан нөхцөлийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэгч этгээдтэй хэлэлцэн тохирох, Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах, гэрээнд гарын үсэг зурах эрхийг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д олгосугай.
3. Зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээний үр дүнг Төлөөлөн Удирдах Зөвлөлд эргэн тайлагнахыг Гүйцэтгэх захирал (Б.Дэлгэржаргал)-д үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:



..... /О.БОЛДБААТАР/